

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

Агуулга	1
1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Шилэн дансны мэдээлэл	8
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	18
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	19
4.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн санхүүжилтийн тайлан	21
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/332
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус байгууллагын дарга Б.Ганзориг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 04-нөөс 2019 оны 2 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дөлгөөнхайрхан уул Аудит ХХК-ийн аудитор Д.Дондог хариуцаж хэрэгжүүлэв.

Улсын Мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборторийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Мал эмнэлгийн ариун цэврийн төв лабортори нь Монгол улсын малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль болон малын эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх, улсын хэмжээнд мал, амьтны элдэв өвчин, хордлогыг оношлон, гадаад дотоодын зах зээлд борлуулах мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн болон хашаа байр, тэжээл, ус, хөрс, ургамалд ариун цэвэр, эрүүл ахуйн үзлэг хийх, шинжилгээний байгууллагуудыг арга зүйн удирдлагаар хангахад оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Монгол улсын засгийн газрын 2009 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 174-р тогтоолоор улсын төсөвт үйлдвэрийн газар (УТҮГ) болон өөрчлөгдөж Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Мал амьтны элдэв халдварт өвчнийг оношилж илрүүлэх, шинжлэн эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, чанарын үнэлгээ хийх, хяналт тавих,
- Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд үзлэг хийж, зөвшөөрөл олгох

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрхзүйн орчны хувьд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабортори нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acoulous Хувилбар 3.0” програм хангамж ашигладаг байна.

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “үр нөлөөтэй” гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 11 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1 хувиар сонгов.

Нийт зардлыг сонгох болсон шалтгаан нь байгууллагын тайлант хугацааны үйл ажиллагааг төлөөлж чадахуйц гэж үзсэнтэй холбоотой.

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал нь 2,461,884.7 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 24,618.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа. Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь эрсдэл багатай гэж үзсэнтэй холбоотой.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 8 чиглэлээр аудитын 11 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)				
№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	1,630.1	
2	Төлбөрийн акт тогтоох	1	953.2	
3	Албан шаардлага өгсөн	1	0.00	
	Дүн	4	2,583.3	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Зардлын данстай холбоотой асуудал

Ажилчдад амралтын мөнгө олгохдоо хоол унааны мөнгө 953.2 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалын 2 дугаар хавсралт "Ээлжийн амралтын олговор тооцох журам", Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тушаалаар баталсан "Дундаж цалин хөлс тодорхойлох журам"-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоох.

2.8.1.2 Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт

Төсвийн цаглабарт хугацаанд санхүүгийн тайланг бэлтгэж ирүүлээгүй, дахин үнэлгээний тайланг баталгаажуулаагүй байна.

Энэ нь Эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйл, Төсвийн зарчим, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйл, Төсвийн цаглабарыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар цалингийн бүртгэл, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийг нарийвчлан үзэх нь зүйтэй.

Анхаарал татахуйц чухал асуудал гараагүй.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 461,023.6 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 627,602.2 мянган төгрөг буюу 98.1 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 7,083.0 мянга, хангамж, бараа материалын зардал 67.6 мянга, нормативт зардал 91.8 мянга, томилолтын зардал 1,779.5 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал 2,994.3 мянган төгрөг тус тус хэмнэснээс шатгаалжээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатор нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж үзэхэд үүргийн биелэлтийг хангалттай биелүүлсэн гэж дүгнэсэн ба 2018

онд сар тутам тайланг оруулсан, улирлын тайлан мэдээг хугацаандаа шивж оруулсныг баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа

3.1.1 Илрүүлэлт:

Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2011 оноос хойш өөрчилж шинэчлээгүй.

Энэ нь Эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүйгээс байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд алдаа гарах

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйл 18.2."Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэснийг мөрдөж хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийн дагуу ажиллана.

3.2 Балансын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Он дамжсан 895.6 төгрөгийн авлага, 734.6 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна. Хариуцах эзэн тодорхойгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй.

Энэ нь Үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6.4.8."Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэснийг зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй байх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Авлага, өглөгийн үлдэгдлийг харилцагч тус бүрээр тооцоо нийлж баталгаажуулах, барагдуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Хүлээн зөвшөөрч байна. Зохих журмын дагуу арга хэмжээ авч барагдуулна

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,021,633,849.04</u>	<u>1,797,513,119.20</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
33	АВЛАГА	895,562.67	117,830,099.30
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	811,940.67	811,940.67
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	116,934,536.63
335	Бусад авлага	83,622.00	83,622.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	83,622.00	83,622.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,020,738,286.37	1,679,683,019.90
351	Түүхий эд материал	968,876,418.73	1,617,957,523.33
35110	Тусгай зориулалттай материал	480,819,932.31	529,138,156.92
35130	Эм боох материал	488,056,486.42	1,088,819,366.41
354	Хангамжийн материал	50,481,867.64	60,345,496.57
35420	Аж ахуйн материал	15,203,032.95	16,999,652.90
35430	Сэлбэг хэрэгсэл	9,905,817.14	10,231,769.14
35440	Түлш, шатах тослох материал	153,220.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	25,219,797.55	33,114,074.53
35600	Мал амьтад	1,380,000.00	1,380,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,902,253,178.68</u>	<u>6,321,501,950.93</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,902,253,178.68	6,321,501,950.93
392	Биет хөрөнгө	4,902,253,178.68	5,877,636,910.93
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,861,097,911.28	1,905,142,660.95
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,716,435,687.34	-2,781,903.36
39203	Авто-тээврийн хэрэгсэл	311,336,539.00	342,436,539.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-255,118,839.20	-266,362,379.24
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	111,320,615.17	112,190,615.17
39206	Хуримтлагдсан элэгдэл	-80,366,637.68	-88,465,601.61
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	763,910,319.61	763,910,319.61
39208	Хуримтлагдсан элэгдэл	-358,195,233.68	-425,393,321.69
39209	Зам, гүүрийн байгууламж	5,124,075,272.31	5,388,380,747.31
39210	Хуримтлагдсан элэгдэл	-2,509,371,080.79	-2,926,420,765.21
39216	Дуусаагүй барилга, байгууламж	650,000,000.00	1,075,000,000.00
393	Биет бус хөрөнгө	00.00	443,865,040.00
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-770,000.00	-770,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,538,460.00	445,403,500.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-1,538,460.00	-1,538,460.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,923,887,027.72</u>	<u>8,119,015,070.13</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>734,560.01</u>	<u>734,560.01</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	734,560.01	734,560.01
413	Өглөг	734,560.01	734,560.01

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5,923,152,467.71</u>	<u>8,118,280,510.12</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	5,923,152,467.71	8,118,280,510.12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,719,719,392.21	6,163,584,432.21
51101	Өмч: - төрийн	5,719,719,392.21	6,163,584,432.21
512	Хуримтлагдсан үр дүн	-151,350,346.54	644,239,653.35
51210	Өмнөх үеийн үр дүн	-462,667,950.74	-151,350,346.54
51220	Тайлант үеийн үр дүн	311,317,604.20	795,589,999.89
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	354,783,422.04	1,310,456,424.56
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>5,923,887,027.72</u>	<u>8,119,015,070.13</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,671,956,629.24	3,306,036,826.38
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,562,152,679.90	223,240,372.00
120	Нийтлэг татварын бус орлого	653,818,951.00	215,140,372.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	653,818,951.00	215,140,372.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	230,393,029.00	215,140,372.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	423,425,922.00	00.00
122	Тусламжийн орлого	908,333,728.90	8,100,000.00
122002	Хандив тусламж /гадаад/	908,333,728.90	8,100,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,109,803,949.34	3,082,796,454.38
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,091,997,389.34	1,032,917,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	384,854,621.55	461,023,900.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	707,142,767.79	571,894,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	1,171,543,155.56
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	490,863,869.66
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	12,400,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	544,276,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	124,003,285.90
1330	Төсвийн захирагчдаас	17,806,560.00	878,335,398.82
133003	Хөрөнгийн	17,806,560.00	878,335,398.82
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,360,639,025.04	2,346,007,183.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,360,639,025.04	2,346,007,183.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,314,551,176.22	2,336,757,183.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	409,054,614.00	485,631,023.29
210101	Үндсэн цалин	339,225,782.00	371,274,895.29
210102	Нэмэгдэл	48,212,400.00	5,652,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,722,000.00	11,722,000.00
210104	Урамшуулал	00.00	70,674,336.00
210105	Гэрээт ажлын хөлс	9,894,432.00	26,307,592.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,195,932.00	64,518,887.04
210201	Тэтгэврийн даатгал	30,179,065.00	41,858,387.04
210202	Тэтгэмжийн даатгал	1,936,584.00	4,295,614.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,397,361.00	9,626,581.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,936,584.00	1,184,805.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,746,338.00	7,553,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,181,541.00	93,259,131.30
210301	Гэрэл, цахилгаан	73,487,180.55	78,655,126.30

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210302	Түлш, халаалт	19,159,851.45	14,604,005.00
210303	Цэвэр, бохир ус	1,534,509.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,086,973.17	79,053,069.50
210401	Бичиг хэрэг	4,093,500.00	2,581,964.00
210402	Тээвэр, шатахуун	20,903,926.00	69,320,427.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,606,105.00	1,333,833.98
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,483,442.17	5,816,844.52
2105	Нормативт зардал	1,040,077,269.65	535,313,232.22
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,018,636,269.65	534,738,732.22
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	21,441,000.00	574,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,785,008.33	27,184,360.50
210601	Багаж, техник, хэрэгсэл	390,000.00	1,200,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,739,873.33	843,753.50
210604	Урсгал засвар	21,655,135.00	25,140,607.00
2107	Томилолт, зочны зардал	71,424,267.50	206,839,306.00
210702	Дотоод албан томилолт	71,424,267.50	206,839,306.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	99,855,592.89	183,086,040.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	91,995,992.89	159,891,217.30
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,188,000.00	1,188,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,474,500.00	2,472,098.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	838,500.00	370,530.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	95,000.00	110,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,782,000.00	17,572,603.00
210807	Газрын төлбөр	1,481,600.00	1,481,592.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	495,889,977.68	612,954,592.41
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,102,419.17	75,829,490.05
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	465,787,558.51	537,125,102.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,087,848.82	58,167,541.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,534,900.00	9,250,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,950,000.00	9,250,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,352,900.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,232,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,552,948.82	48,917,541.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,552,948.82	48,917,541.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>311,317,604.20</u>	<u>960,029,642.80</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	164,439,642.91
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	164,439,642.91
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-164,439,642.91
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>311,317,604.20</u>	<u>795,589,999.89</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,038,673,572.55</u>	<u>1,847,707,427.56</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	653,818,951.00	215,140,372.00
120	Нийтлэг татварын бус орлого	653,818,951.00	215,140,372.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	653,818,951.00	215,140,372.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	230,393,029.00	215,140,372.00
1200045	Төсөл хөтөлбөрийн орлого	423,425,922.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	384,854,621.55	1,632,567,055.56
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	384,854,621.55	461,023,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	384,854,621.55	461,023,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	1,171,543,155.56
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	490,863,869.66
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	12,400,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	544,276,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	124,003,285.90
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,038,673,572.55</u>	<u>1,815,737,427.56</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,038,673,572.55	1,815,737,427.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	992,585,723.73	1,640,635,349.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	409,054,614.00	485,631,023.29
210101	Үндсэн цалин	339,225,782.00	371,274,895.29
210102	Нэмэгдэл	48,212,400.00	5,652,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,722,000.00	11,722,000.00
210104	Урамшуулал	00.00	70,674,336.00
210105	Гэрээт ажлын хөлс	9,894,432.00	26,307,592.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,195,932.00	64,518,887.04
210201	Тэтгэврийн даатгал	49,195,932.00	41,858,387.04
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	4,295,614.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	9,626,581.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	1,184,805.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	7,553,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,181,541.00	93,259,131.30
210301	Гэрэл, цахилгаан	73,487,180.55	78,655,126.30
210302	Түлш, халаалт	19,159,851.45	14,604,005.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,555,770.00	74,351,369.98
210401	Бичиг хэрэг	3,638,799.00	2,913,660.00
210402	Тээвэр, шатахуун	21,057,146.00	69,062,983.00

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,705,655.00	1,601,836.98
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,154,170.00	772,890.00
2105	Нормативт зардал	211,298,358.00	378,788,163.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	189,451,358.00	378,473,363.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	21,847,000.00	314,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,193,732.00	91,981,137.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,340,000.00	77,103,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,546,498.00	2,516,130.00
210604	Урсгал засвар	16,307,234.00	12,361,607.00
2107	Томилолт, зочны зардал	71,424,267.50	202,929,130.00
210702	Дотоод албан томилолт	71,424,267.50	202,929,130.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	97,743,350.23	235,427,503.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	89,883,750.23	210,087,680.70
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,188,000.00	1,188,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,474,500.00	2,472,098.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	838,500.00	370,530.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	95,000.00	110,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,782,000.00	19,717,603.00
210807	Газрын төлбөр	1,481,600.00	1,481,592.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,938,159.00	13,749,004.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,938,159.00	13,749,004.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,087,848.82	175,102,077.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,534,900.00	9,250,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,950,000.00	9,250,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,352,900.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,232,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,552,948.82	165,852,077.65
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,552,948.82	117,289,995.52
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>00.00</u>	<u>31,970,000.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	<u>00.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	31,970,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	31,970,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	31,970,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	31,970,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>-31,970,000.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	00.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,719,719,392.21	354,783,422.04	-462,667,950.74	5,257,051,441.47
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	311,317,604.20	311,317,604.20
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,719,719,392.21	354,783,422.04	-151,350,346.54	5,568,369,045.67
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,719,719,392.21	354,783,422.04	-151,350,346.54	5,923,152,467.71
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	955,673,002.52	-	955,673,002.52
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	443,865,040.00	-	-	443,865,040.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	795,589,999.89	795,589,999.89
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,163,584,432.21	1,310,456,424.56	644,239,653.35	8,118,280,510.12

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	639,618,300.00	627,602,189.87	12,016,110.13	98.1
УРСГАЛ ЗАРДАЛ	639,618,300.00	627,602,189.87	12,016,110.13	98.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	630,368,300.00	618,352,189.87	12,016,110.13	98.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	377,671,700.00	377,671,695.29	04.71	100
Үндсэн цалин	360,297,500.00	360,297,495.29	04.71	100
Нэмэгдэл	5,652,200.00	5,652,200.00	00.00	100
Унаа хоолны хөнгөлөлт	11,722,000.00	11,722,000.00	00.00	100
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,874,200.00	52,874,200.00	00.00	100
Тэтгэврийн даатгал	52,874,200.00	30,213,700.00	22,660,500.00	57.1
Тэтгэмжийн даатгал	00.00	4,295,614.00	-4,295,614.00	-
ҮОМШӨ-ний даатгал	00.00	9,626,581.00	-9,626,581.00	-
Ажилгүйдлийн даатгал	00.00	1,184,805.00	-1,184,805.00	-
Эрүүл мэндийн даатгал	00.00	7,553,500.00	-7,553,500.00	-
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	100,342,100.00	93,259,131.30	7,082,968.70	92.9
Гэрэл, цахилгаан	75,945,000.00	78,655,126.30	-2,710,126.30	103.6
Түлш, халаалт	17,779,000.00	14,604,005.00	3,174,995.00	82.1
Цэвэр, бохир ус	6,618,100.00	00.00	6,618,100.00	-
Хангамж, бараа материалын зардал	8,948,800.00	8,881,223.98	67,576.02	99.2
Бичиг хэрэг	1,679,000.00	1,647,160.00	31,840.00	98.1
Тээвэр, шатахуун	4,924,500.00	4,984,337.00	-59,837.00	101.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,752,000.00	1,476,836.98	275,163.02	84.3
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	593,300.00	772,890.00	-179,590.00	130.3
Нормативт зардал	6,341,100.00	6,249,326.00	91,774.00	98.6
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,940,000.00	5,934,526.00	5,474.00	99.9
Нормын хувцас, зөөлөн эдлэл	401,100.00	314,800.00	86,300.00	78.5
Эд хогшил, урсгал засварын зардал	2,372,600.00	2,372,567.00	33.00	100
Багаж, техник, хэрэгсэл	390,200.00	353,400.00	36,800.00	90.6
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	671,600.00	616,130.00	55,470.00	91.7
Урсгал засвар	1,310,800.00	1,403,037.00	-92,237.00	107
Томилолт, зочны зардал	3,680,300.00	1,900,800.00	1,779,500.00	51.6
Дотоод албан томилолт	3,680,300.00	1,900,800.00	1,779,500.00	51.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	77,147,500.00	74,153,246.30	2,994,253.70	96.1

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	49,754,300.00	48,813,423.30	940,876.70	98.1
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,188,000.00	1,188,000.00	-	100
Даатгалын үйлчилгээ	2,475,000.00	2,472,098.00	2,902.00	99.9
Тээврийн хэрэгслийн татвар	852,800.00	370,530.00	482,270.00	43.4
Тээврийн хэрэгслийн оношлогоо	113,800.00	110,000.00	3,800.00	96.7
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	21,282,000.00	19,717,603.00	1,564,397.00	92.6
Газрын төлбөр	1,481,600.00	1,481,592.00	08.00	100
Бараа үйлчилгээний бусад зардал	990,000.00	990,000.00	-	100
Бараа үйлчилгээний бусад зардал	990,000.00	990,000.00	-	100
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,250,000.00	9,250,000.00	-	100
Бусад урсгал шилжүүлэг	9,250,000.00	9,250,000.00	-	100
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,250,000.00	9,250,000.00	-	100
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	639,618,300.00	627,602,189.87	12,016,110.13	98.1
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	461,023,900.00	412,461,817.87	48,562,082.13	89.5
Улсын төсвөөс санхүүжих	461,023,900.00	412,461,817.87	48,562,082.13	89.5
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	178,594,400.00	215,140,372.00	-36,545,972.00	120.5
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	178,594,400.00	215,140,372.00	-36,545,972.00	120.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	-	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	00.00	00.00	-	-
АЖИЛЛАГСАДЫН ТОО	52.00	52.00	-	100
Удирдах ажилтан	01.00	01.00	-	100
Гүйцэтгэх ажилтан	41.00	41.00	-	100
Үйлчлэх ажилтан	10.00	10.00	-	100

4.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,140,443,155.56	-1,140,443,155.56	
УРСГАЛ ЗАРДАЛ		1,140,443,155.56	-1,140,443,155.56	
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,023,153,160.04	-1,023,153,160.04	
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		107,959,328.00	-107,959,328.00	
Үндсэн цалин		10,977,400.00	-10,977,400.00	
Урамшуулал		70,674,336.00	-70,674,336.00	
Гэрээт ажлын хөлс		26,307,592.00	-26,307,592.00	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		11,644,687.04	-11,644,687.04	
Тэтгэврийн даатгал		11,644,687.04	-11,644,687.04	
Хангамж, бараа материалын зардал		65,470,146.00	-65,470,146.00	
Бичиг хэрэг		1,266,500.00	-1,266,500.00	
Тээвэр, шатахуун		65,078,646.00	-65,078,646.00	
Шуудан холбоо, интернэтийн төлбөр		125,000.00	-125,000.00	
Норматив зардал		373,408,837.00	-373,408,837.00	
Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл		373,408,837.00	-373,408,837.00	
Эд хогшил худалан авах		89,608,570.00	-89,608,570.00	
Багаж, техник, хэрэгсэл		76,750,000.00	-76,750,000.00	
Хөдөлмөрийн хамгааллын хэрэгсэл		1,900,000.00	-1,900,000.00	
Урсгал засвар		10,958,570.00	-10,958,570.00	
Томилолт, зочны зардал		201,028,330.00	-201,028,330.00	
Дотоод албан томилолт		201,028,330.00	-201,028,330.00	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		161,274,257.40	-161,274,257.40	
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр		161,274,257.40	-161,274,257.40	
Бараа үйлчилгээний бусад зардал		12,759,004.60	-12,759,004.60	
Бараа үйлчилгээний бусад зардал		12,759,004.60	-12,759,004.60	
Урсгал шүлжүүлэг		117,289,995.52	-117,289,995.52	
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		117,289,995.52	-117,289,995.52	
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		117,289,995.52	-117,289,995.52	
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		31,100,000.00	-31,100,000.00	
Дотоод эх үүсвэр		31,100,000.00	-31,100,000.00	
Тоног төхөөрөмж		31,100,000.00	-31,100,000.00	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		1,171,543,155.56	-1,171,543,155.56	
Нэмэлт санхүүжилтийн орлого		1,171,543,155.56	-1,171,543,155.56	
Төрийн болон орн нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		490,863,869.66	-490,863,869.66	
ЗГНХ, Засгийн газрын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		12,400,000.00	-12,400,000.00	
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		544,276,000.00	-544,276,000.00	
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд нэмэлт орлого		124,003,285.90	-124,003,285.90	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2019.02.25	Аудитын нэр: Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2019/150/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл Нэр	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	Төсвийн цаглабарт хугацаанд санхүүгийн тайланг бэлтгэж ирүүлээгүй, дахин үнэлгээний тайланг баталгаажуулаагүй байх		Албан шаардлага өгөх	Нягтлан бодогч	Т.Даваажаргал
2	Тайлант онд нийт ажилтны ээлжийн амралтын олговрыг тооцоходоо цалин хөлсний дүнд хоол унааны хөнгөлөлтийг оруулж тооцсон байна.	953.2	Төлбөрийн акт тогтоох	Нягтлан бодогч	Т.Даваажаргал
3	Санхүүгийн тайланд тусгасан богино хугацаат авлага, өглөгийн дүнг дэлгэрэнгүй журналаас харилцагч тус бүрээр задалж, авлага, өр төлбөрийн үлдэгдэлтэй тулган шалгахад он дамжсан үлдэгдлүүд нь хариуцах эзэн тодорхойгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1,630.2	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Т.Даваажаргал
4	Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2011 оноос хойш шинэчлээгүй.		Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Т.Даваажаргал
	Дүн	2,583.3			

